



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

[2011 оны 11 сарын 30 өдөр](#)

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2012 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Хүний хөгжил санд 2012 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах хөрөнгийн хэмжээ, эрсдэлийн нөөц хөрөнгийн хэмжээ, зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### **2 дугаар зүйл.Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хууль тогтоомж**

2.1.Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай<sup>1</sup>, Төсвийн тогтвортой байдлын тухай<sup>2</sup>, Хүний хөгжил сангийн тухай хууль<sup>3</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2012 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЭХ ҮҮСВЭР, САНГААС ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛИЙН НӨӨЦ ХӨРӨНГӨ

**3 дугаар зүйл.**Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн жилийн орлогын хэмжээ, эх үүсвэрийг дор дурдсанаар баталсугай:

3.1.Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1-д заасан орлого 110,000.0 сая төгрөг;

<sup>1</sup> Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 44 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Хүний хөгжил сангийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2009 оны 45 дугаарт нийтлэгдсэн.

3.2.Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.2-т заасан орлого 364,638.1 сая төгрөг;

3.3.Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.4-т заасан эх үүсвэр 312,495.6 сая төгрөг;

3.4.Эрсдэлийн нөөц хөрөнгө 0.0 төгрөг.

**4 дүгээр зүйл.**Хүний хөгжил сангийн хөрөнгөөр 2012 оны төсвийн жилд санхүүжүүлэх хишиг, хувийн хэмжээг дор дурдсанаар баталсугай:

4.1.эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрт 10,900.0 сая төгрөг;

4.2.бэлэн мөнгө 692,600.4 сая төгрөг;

4.3.оюутны сургалтын төлбөрт 83,633.2 сая төгрөг.

#### **ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ